

## Түүх 8: Исаак ба Ребека

Библийн эшлэл  
[Эхлэл 24:67]

Исаак Ребекаг эх Сарагийнхаа майханд дагуулан ороод, түүнийг эхнэрээ болгон авч, хайрлан дурлажээ. Эхийгээ нас барснаас хойших Исаакийн үй гашуу ингэж тайлагдав.

Абрахам Исаакийг гэрлүүлэхээр болжээ. Абрахамд төрсөн нутгаасаа эхнэр болох хүнийг авч өгөх санаа төржээ.

Тэгээд гэрийнхээ бүх хэргийг хариуцдаг хамгийн итгэмжит зарцаа дуудав.

“Чи миний нутаг болох Хараан уруу очоод Исаакт тохирох эхнэрийг олж ир.” гэв.

Тэгээд зарц нь холын аян замд гарав. Үдэш болоход зарц нь Хараанд ирэв.

Тэрээр холын аян замдаа ядран ордны гаднах худгийн хажууд суун амарч байлаа.

Тэгээд зарц худгийн хажууд өвдөг сөгдөн Бурханд хандан залбирчээ.

“Бурхан минь, Ваараа тонгойлгож уснаасаа надад уулган мөн тэмээнүүдийг минь хүртэл услах тэр охиныг Исаакт эхнэр болгох болтугай.” гэв.

Зарцыг үгээ хэлж дуусаагүй байтал, нэгэн охин мөрөн дээрээ ваартай гарч ирэв.

Тэгээд зарц хэсэг харж байснаа түүнд дөхөн очоод ингэж хэлэв.

“Нэг аяга ус өгөөч” гэхэд Ребека ингэж хариулав.

“Эзэн минь уснаас уугтун. Таны тэмээнүүдийг ч бас ханатал услаад өгье.” гэв.

Энэ үгийг сонссон зарц нь ихэд гайхав.

“Аа яа, Бурхан миний залбиралыг сонсчээ. Энэ охин Исаакийн эхнэр болох эмэгтэй байх нь ээ.”

Тэр охиныг Ребека гэдэг байв.

Зарц болон Ребека нар Абрахамын амьдарч буй нутаг руу хөдөлцгөөв.

Тэднийг ирэх үед, Исаак хээр талаар явж байжээ.

Зарц нь түүнийг ирэхэд болсон бүхнийг ярьж өгчээ.

Исаак, Ребекаг дагуулан гэртээ ирэв.

Тэгээд олон хүний ерөөл дотор тэд хуримаа хийцгээжээ.





а. Абрахам болон түүний зарц нь хэнд эхнэр хайж байсан бэ?

-----

б. Исаакийн эхнэрийг хайхаар Абрахамын зарц нь аль хот руу явсан бэ?

-----

с. Абрахамын зарц нь Исаакийн эхнэр болох бүсгүйг таних шинж тэмдэг нь юу байсан бэ?

-----

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Эхлэл 24:67)

түүнийг эхнэрээ болгон авч, хайрлан дурлажээ.



